

## ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2023 оны нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Газрын даргын 01/09-02 дугаар удирдамжийн дагуу дотоод аудит хийж гүйцэтгэв.

Тус шалгалтаар төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын зохих мэдээллийг анхан шатны баримтад үндэслэн нэгдүгээр улиралд байгууллагын хэмжээнд цахим хуудсанд 333 мэдээлэл байршуулахаас 331 мэдээллийг байршуулж 99.3 хувийн үзүүлэлттэй “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдэж байгаа хэдий ч сар, улирлаар хийгдсэн хяналт шалгалтаар зарим мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил гарч байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчиж байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;
- Шилэн дансны сайт гацах, мэдээллийг хоцроох байдал үүсдэг тул цагийг нь тулгахгүйгээр хийх, хэрэгжилтийн хувийг бууруулахгүйгээр 7 хоног, сар, улирал тутам хуулийн хугацаанд мэдээлэх, мэдээллийг хоцроохгүй байх;
- Удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэл, албан даалгавар, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Төсвийн шууд захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;
- Байгууллагын шилэн дансны мэдээллийн самбарт төсөв, санхүүгийн холбогдох мэдээллийг тогтмол байршуулж хэвших;

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан, түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтний [jargalmaa.i@immigration.gov.mn](mailto:jargalmaa.i@immigration.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ үү.